

“АЛБАНЫ БЭЛТГЭЛИЙН ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЦЭЭ
ШААРДЛАГА, АЧ ХОЛБОГДОЛ”

“THE NECESSITY, REQUIREMENTS, AND IMPORTANCE OF
PROFESSIONAL TRAINING COURSES”



С.Эрдэнэбат

*Дотоод хэргийн их сургуулийн Биеийн
тамир, албаны бэлтгэлийн институтын ахлах багш,
дэд хурандаа*

Хураангуй: Албаны бэлтгэлийн хичээлийн зорилго нь бие бялдар хүмүүжлийн онол заах арга зүйн үндсэн дээр тулгуурлан сонсогч нарт шинжлэх ухааны сурган хүмүүжүүлэх, сэтгэл зүй, сургахуйн онол арга зүйг орчин үеийн түвшинтэй тохирч, хууль эрх зүйн үндсэн дээр тулгуурлан бүх бие хамгаалах урлагийн эвсэл хөдөлгөөнүүд, тулалдах чадвар дадлыг бүрэн эзэмшүүлж мэргэшүүлэхэд оршино.

Судалгааны үндсэн зорилго нь бие хамгаалах урлаг, албаны бэлтгэлийн хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон, эдгээрийг шийдвэрлэх арга замыг боловсруулах явдал юм.

Summary: The objective of the *Professional Training* course is to provide cadets with a comprehensive understanding and mastery of defensive techniques and combat skills based on legal foundations and modern pedagogical, psychological, and didactic principles. The course is grounded in the theory and methodology of physical education, aiming to develop professional proficiency in all forms of defensive martial arts through scientifically informed teaching strategies.

The main purpose of the research is to identify the needs, challenges, and pressing issues related to defensive martial arts and professional training, and to develop effective solutions to address them.

Түлхүүр үг: Биеийн тамир, сэтгэл зүйн бэлтгэл, багшийн арга барил, эрүүл мэнд, сургалтын чанар, албаны бэлтгэл, хичээлийн үр нөлөө, оролцооны идэвх, тоног төхөөрөмж, сургалтын бодлого, техник хэрэгсэл

Keywords: Physical education, psychological preparation, teaching methodology, health, quality of training, professional (or official) training, lesson effectiveness, participation engagement, equipment, training policy, technical tools

ҮНДСЭН ХЭСЭГ

Орчин үеийн нийгэмд аюулгүй байдал, хамгаалалт нь маш чухал ач холбогдолтой асуудал болж байна. Энэхүү асуудал нь ганц хүнээс эхлээд томоохон байгууллага, төрийн алба, төрийн аюулгүй байдлыг хариуцсан байгууллагууд хүртэл бүх түвшинд хамааралтай. Бие хамгаалах урлаг, албаны бэлтгэл нь хүний бие махбод, сэтгэл зүй, стратегийн ур чадварыг хөгжүүлэх замаар аливаа аюулаас хамгаалах чухал механизм болдог. Бие хамгаалах урлаг, албаны бэлтгэл нь нийгмийн аюулгүй байдал, хувь хүний өөрийгөө хамгаалах чадвар, мэргэжлийн ур чадвар эзэмших шаардлагыг хангах чухал хүчин зүйл юм

Албаны бэлтгэл гэдэг нь тухайн албаны ажилтан буюу мэргэжилтнүүдийн ажлын явцад өөрийн үүргийг гүйцэтгэх, аюулгүй байдлыг хангах, мэргэжлийн ур чадвараа сайжруулах зорилготой бэлтгэл юм. Албаны бэлтгэлийн хүрээнд бие хамгаалах урлагийн тусгай техник, тактик, зэвсэг хэрэгслийн хэрэглээ, тухайн албан үүрэгт тохирсон эрсдэлийн менежмент зэрэг шаардлагууд орно.

Албаны бэлтгэлийг хийдэг гол байгууллагууд нь цагдаагийн алба, цэргийн байгууллагууд, аюулгүй байдлын байгууллагууд.

Албаны бэлтгэлийн төрлүүд

- **Цагдаа, аюулгүй байдлын албан хаагчдын бэлтгэл:** Үүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах, аюултай нөхцөлд шаардлагатай хариу арга хэмжээ авах чадварыг эзэмших сургалтууд орно
- **Тусгай хүчний албаны бэлтгэл:** Тусгай ангиудын бэлтгэл нь өндөр хурд, хүч чадал, сэтгэл зүй, тактикийн ур чадварыг шаарддаг бөгөөд зөвхөн тулааны урлаг биш, тэр ч байтугай нөхцөл байдлыг бүрэн дүүрэн ойлгож, хариу үйлдэл хийхэд чиглэгддэг.
- **Хувийн хамгаалагчдын бэлтгэл:** Хувийн хамгаалагчид. VIP хамгаалалтын салбар дахь хүмүүсийг хамгаалахад шаардагдах ур чадваруудыг эзэмших сургалтууд

Албаны бэлтгэлийн ач холбогдол

Албаны бэлтгэл нь аюултай нөхцөлд тухайн албан хаагчийг хэрхэн үр дүнтэй ажиллах талаар зааж өгдөг. Тусгай хүчний ангиуд болон аюулгүй байдлын алба хаагчид өөрсдийн даалгаврыг амжилттай биелүүлэхийн тулд мэдлэг, ур чадвараа тасралтгүй шинэчилж, бэлтгэлд хамрагддаг.

Бэлтгэгдсэн албаны хүмүүс аюултай нөхцөлд цаг тухайд нь хариу үйлдэл хийж, олон хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах чадвартай болдог.

АЛБАНЫ БЭЛТГЭЛИЙН ШААРДЛАГА

Албаны бэлтгэл нь хэд хэдэн чухал шаардлагыг тавьдаг:

- Физик бэлтгэл: Биеийн хүч, тэсвэр, хурд, тэнцвэрийг сайжруулах.
- Техникийн бэлтгэл: Газар дээрх болон агаарын нөхцөлд хэрхэн ажиллах ур чадвар
- Сэтгэл зүйн бэлтгэл: Сэтгэл санааны тэсвэр, стрессийн удирдлага, хурдан шийдвэр гаргах чадвар.
- Мэргэжлийн бэлтгэл: Тухайн албан үүрэгт тохирсон хэрэгсэл, техник, зэвсэг хэрэгслийн ашиглалт.

Нийгмийн аюулгүй байдал

Өнөө үед гэмт хэрэг, терроризм, байгалийн гамшиг гэх мэт олон төрлийн аюул бий болсон. Энэ нь бие хамгаалах урлаг болон албаны бэлтгэлийг эрэлт хэрэгцээтэй болгож байна. Мөн, алба хаагчийг бэлтгэхдээ түүний сэтгэл зүйн бэлтгэлийг анхаарах нь чухал байдаг. Цагдаа, тусгай хүчний байгууллагууд нь албаны бэлтгэлийг олгох замаар иргэдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Албаны бэлтгэл нь аюултай нөхцөлд хурдан, зөв шийдвэр гаргах чадварыг олгодог. Энэ нь тухайн хүний сэтгэл зүйн бэлтгэлийг бий болгож, стрессийн нөхцөлд ажиллах чадварыг нэмэгдүүлдэг.

Албаны тусгай бэлтгэлжилтийн хичээл, зохион байгуулалт сургалт арга зүйн бүтцийн уялдаа холбоо, албаны тусгай бэлтгэлжилтийн хичээлийн явцад суралцагчдын бие бялдрын зөв хөгжил, бие хамгаалах урлагийн хөдөлгөөний чадвар дадлыг олгоод зогсохгүй эр зоригийн хүмүүжил, бие бялдрын соёлыг эзэмшүүлнэ. Мөн хэрэг зөрчил гаргасан этгээдийг эрэн сурвалжлах баривчлах үеийн тактик, галт зэвсэг чадварлаг эзэмших, ард иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэнэтийн гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх арга зүйд суралцуулна.

Бие хамгаалах урлаг нь бие махбодын болон сэтгэл зүйн хувьд өөрийгөө болон бусдыг аюултай нөхцөл байдалд хамгаалах ур чадвар, арга техник юм. Энэ нь зөвхөн халдлагаас сэргийлэх төдийгүй хууль сахиулах, хамгаалалтын алба хаагчдын ажил үүргийг аюулгүй, үр дүнтэй гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэгддэг.

ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Энэхүү судалгаа нь бие хамгаалах урлагийн сургалтын олон улсын шилдэг туршлагыг судалж, Монгол Улсад хэрэгжүүлэх боломж, арга замыг тодорхойлох зорилготой. Энэ нь үндэсний аюулгүй байдал, хувь хүний болон алба хаагчдын аюулгүй байдлыг сайжруулахад чухал ач холбогдолтой. Судалгааны ажлын хүрээнд АНУ, Япон, Өмнөд Солонгос, ОХУ зэрэг орнуудад хэрэгжиж буй бие

хамгаалах сургалтын хөтөлбөрийг Цэргийн, цагдаагийн болон иргэний сургалтын арга барил, техникүүдийг харьцуулан судаллаа.

АНУ

Хөтөлбөрийн онцлог:

Хуулийн байгууллагад зориулсан бие хамгаалах урлагийн сургалтад тактик, сэтгэлзүйн сургалтыг хослуулдаг.

"Defensive Tactics" гэх мэт нэртэй сургалтуудад үндэслэн алба хаагчид өөрийгөө болон бусдыг гэмт хэргээс хамгаалах аргыг сурдаг.

Тогтмол дадлага хийх сургалт

Бодит нөхцөлд суурилсан симуляци ашиглах.

Япон улс

Хөтөлбөрийн онцлог:

Бие хамгаалах урлагт Жүдо, Кендо зэрэг уламжлалт урлагийг сургалтын үндсэн хэсэг болгон ашигладаг.

Сургалт зөвхөн биеийн хүч төдийгүй ёс зүй, сахилга батыг хөгжүүлэхэд чиглэдэг. Ёс зүй, сахилга батад тулгуурласан хөтөлбөр.

Алба хаагчдын бие болон сэтгэлзүйн бэлтгэлийг тэнцвэртэй хөгжүүлдэг.

БНСУ

Хөтөлбөрийн онцлог:

Бие хамгаалах сургалтад таеквондог түлхүү ашигладаг.

Алба хаагчдыг сэтгэлзүйн бэлтгэлийг бодит байдалд тулгуурлан хөгжүүлдэг.

Өндөр түвшний техник, тоног төхөөрөмж ашиглах.

Сургалтыг технологиор баяжуулсан (VR симуляци).

ОХУ

Хөтөлбөрийн онцлог:

Самбо зэрэг үндэсний бие хамгаалах урлагийг сургалтын үндэс болгон ашигладаг. Сургалт албаны ажилд хэрэгцээтэй тактикийг сайжруулахад чиглэгддэг.

Хөдөлгөөнт сургалтын хөтөлбөр.

Хууль сахиулах байгууллагуудын оролцоотой сургалт.

Монгол дахь сургалтын байдал

Одоогийн нөхцөл:

Бие хамгаалах урлагийн сургалт цагдаа, цэрэг, онцгой байдлын байгууллагуудад зохион байгуулагддаг.

Сургалтын агуулга нь биеийн хүчний бэлтгэлд илүү анхаардаг ч сэтгэлзүйн сургалт хангалтгүй.

Сургалтын хүртээмж орон нутгийн түвшинд сул байна.

ДҮН ШИНЖИЛГЭЭ

Олон улсын шилдэг туршлагын давуу тал:

- Тогтмол дадлага, бодит нөхцөлд тулгуурласан сургалт.
- Ёс зүй, сахилга бат, сэтгэлзүйн бэлтгэлийг хослуулсан сургалтын систем.
- Орчин үеийн технологи ашигласан сургалтын арга барил.

Монголд хэрэгжүүлэх боломж:

Ёс зүй, сахилга батыг хөгжүүлэх уламжлалт арга барилыг сургалтад тусгах.

Технологийг сургалтанд нэвтрүүлэх (симуляци, VR).

Сургалтын хөтөлбөрт сэтгэлзүйн бэлтгэлийг нэмэх

Бие хамгаалах урлагт үндэсний уламжлалыг шингээх (Монгол бөх, уламжлалт спортын элемент).

Олон улсын туршлагыг хэрэгжүүлэхэд дасан зохицох хугацаа шаардагдана.

Тулгарч буй бэрхшээлүүд:

- Сургалтын стандарт, аргачлалын хомсдол.

Нэгдсэн стандартгүй: Бие хамгаалах урлаг, албаны бэлтгэлийн сургалтад нэгдсэн стандарт, арга зүй дутмаг байна

- Мэргэшсэн багш, сургагч нарын дутагдал.

Сургалтыг чанартай явуулах чадварлаг, мэргэжлийн багш дутагдалтай. Материаллаг бааз, техник хэрэгслийн хүрэлцээгүй байдал.

Сургалтад зориулсан байр, тоног төхөөрөмж, хэрэгсэл хангалтгүй.

- Сургалтын хөтөлбөрт ёс зүй, сэтгэлзүйн бэлтгэл орхигдсон.

Бие хамгаалах сургалтад зөвхөн биеийн хүчний сургалтыг анхаарч, сэтгэлзүйн чадавхыг үл тоомсорлодог. Алба хаагчид бодит аюултай нөхцөлд ажиллахад сэтгэлзүйн дарамтад өртөх эрсдэлтэй.

ДҮГНЭЛТ

Бие хамгаалах урлаг, албаны бэлтгэл нь зөвхөн тулааны урлаг биш, харин аливаа аюултай нөхцөлд хариу арга хэмжээ авах, хамгаалалт хийх, сэтгэл зүй, стратеги хэрэглэх чухал ур чадваруудыг хамарсан цогц систем юм. Түүний

хэрэгцээ, шаардлага нь нийгмийн аюулгүй байдал, гэмт хэрэг, терроризм, байгалийн гамшиг зэрэг аюултай нөхцөлүүдийн хариуд бэлтгэгдсэн, мэргэжлийн хүмүүсийн чадавхыг бүрдүүлдэг. Энэ нь хүмүүсийг аюулгүй байдалд бүрэн дүүрэн хариу үйлдэл хийх, өөрийгөө болон бусдыг хамгаалах боломжийг олгоно. Олон улсын туршлага нь Монгол Улсад бие хамгаалах урлагийн сургалтыг сайжруулах олон боломжийг харуулж байна. Гэхдээ эдгээрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд сургалтын хөтөлбөр, санхүүжилт, сургалтын арга барилыг сайжруулахад анхаарах шаардлагатай.

Судалгааны үр дүнгээс харахад, бие хамгаалах урлаг болон албаны бэлтгэл нь хувь хүний болон нийгмийн аюулгүй байдалд чухал үүрэгтэй. Мэргэжлийн ур чадвар, сэтгэл зүй, анхаарал, шийдвэр гаргах чадвар нь нийгэмд аюулгүй байдлыг хангах, эрсдэлтэй нөхцөлд амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чухал ач холбогдолтой. Тиймээс бие хамгаалах урлагийг сургах, албаны бэлтгэлийг сайжруулах нь нийгмийн хөгжилд чухал хувь нэмэр оруулах юм.

САНАЛ

Судалгааны ажлын хүрээнд гадаадын зарим орны болон өөрийн улсын албаны тусгай бэлтгэлжилтийн хичээл, зохион байгуулалт сургалт арга зүйн бүтцийн уялдаа холбоог судлан дараах саналыг гаргаж байна.

Сургалтын хөтөлбөр шинэчлэх;

Олон улсын сургалтын хөтөлбөрөөс суралцан, Монголд тохируулсан арга зүй боловсруулах;

Сэтгэлзүйн бэлтгэлийг сургалтын гол бүрэлдэхүүн хэсэг болгох;

Материаллаг орчныг сайжруулах;

Сургалтын төв, тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх;

Олон улсын туршлагад ашиглагдаж буй VR симуляци, дижитал сургалтын хөтөлбөрийг Монголд нэвтрүүлэх;

Мэргэжлийн багш нарыг хөгжүүлэх, гадаадын сургалт, дадлагын хөтөлбөрт багш нарыг хамруулах.

ЭХ СУРВАЛЖ, НОМ ЗҮЙ

"Бие хамгаалах урлаг ба сэтгэлзүйн бэлтгэл" - Монголын мэргэжлийн сургалтын холбоо

"Албаны тусгай бэлтгэлжилт" Д.Дашмягмар 2003 он

"Цэргийн бэлтгэлийн арга зүй" - Батлан хамгаалахын их сургууль.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)